



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА А.МӨНХ-ОРГИЛ ТАНАА

2025. 05. 19 № 9/1102
танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 07-оос 2025 оны 05 дугаар сарын 09-ний хооронд сумдад ажиллаж бодлогын баримт бичгийн төлөвлөлт, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан Засаг даргын 2025 оны А/42 дугаар захирамжаар сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.

Тус хөтөлбөрт аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Ирээдүйн эзэд, Хөгжлийн хөтөч, Нутгийн ирээдүй хөтөлбөрүүд тусгагдаагүй орхигдсон байна.

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан боловч төсөвт байгууллагын заалтыг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй, төрийн жинхэнэ албан хаагчид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зорилт, арга хэмжээ болгон задалж өөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй буюу байгууллагын төлөвлөгөөнөөс шууд хуулж тавьсан байна. Иймд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орхигдсон хөтөлбөрүүдийг нэмж, шаардлагатай засваруудыг хийж дахин батлуулах шаардлагатай талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа

231060204

Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог жил бүр шинэчлэн баталдаг. Төсвийн шууд захирагч болон төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны захиалгыг томилох эрх бүхий албан тушаалтан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж хэвшсэн. Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтэд зарим албан хаагчийн төрийн албаны нөөцөд бүртгэгдсэнийг нотлох баримт бичиг, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нэр дэвшүүлсэн тогтоол байхгүй, хөдөлмөр эрхлэлтийн тушаал шийдвэр дутуу, албан тушаалын картыг бүрэн гүйцэд хөтлөөгүй зэрэг дутагдал байгаа тул хүний нөөцийн шийдвэр гаргах, хувийн хэргийн бүрдүүлэлт, албан тушаалын картыг зөв хөтлөх зэрэг анхаарах зүйлсийн талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Зөвлөмж: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан сумдад хамааралтай заалт арга хэмжээ, холбогдох хөтөлбөрүүдийг бүрэн тусгах

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар буюу батлагдсан загварын дагуу тус тус төлөвлөх (сумын Соёлын төв анхаарах)

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжүүлэх заалт арга хэмжээг бүрэн тусгах

4. Аймгийн Засаг даргын 2022 оны А/289 захирамжийн хавсралтын дагуу тайлангуудыг заасан хугацаанд тайлагнах, тайланг хэн хариуцах талаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзэнжүүлэн тусгах

5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт, арга хэмжээний жагсаалт гарган эзэнжүүлж, байгууллагын даргаар баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах тухай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах

6. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар төлөвлөх

7. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан өөрт хамааралтай арга хэмжээ болгоныг төрийн жинхэнэ албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилт болгож аваад

3.

нарийвчлан задалж боловсруулах (албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг тусгах)

8. Бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө тавигдах шаардлагын дагуу шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нарийвчилсан байдлаар оновчтой тодорхойлох

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс хийсэн хяналт, шалгалт

1. Бүтэц, орон тооны шийдвэрийг жил бүр батлах шаардлагагүй бөгөөд Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан орон тооны хязгаарт багтааж ажиллуулах ба чиг үүрэг бүтэц, хүн амын тоо өөрчлөгдсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн орон тооны хязгаарт багтааж бүтэц, орон тоо баталсан шийдвэрийг дахин өөрчлөх

2. Хүний нөөц бүрдүүлэх, албан хаагчдыг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах

3. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах, албан тушаалын картыг зөв, хөтлөх

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЖАРГАЛСАЙХАН